

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2021 оны 9 сарын байдлаар/

№	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт дүн
1	Нийт үзлэг	48589	97818	70586	30492	4188	249473
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	15256	46438	38098	4118	3774	107684
3	Идэвхтэй хяналтын үзлэг	6017	17804	15520	3131		42472
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	15890	14248	4748	7705	258	42849
5	Нийт төрөлт	983	252				1235
6	Хэвтэн эмчлүүлэгчид	5199	3432		2398	33	11062
7	Нас баралт	25	128	78			231

№	Үзүүлэлт	<u>2020.9</u>	2021.9	Өөрчлөлт
1	Нийт үзлэг	259407	249473	-9934
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	83888	107684	23796
3	Идэвхтэй хяналтын үзлэг	43302	42472	-830
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	61077	42849	-18228
5	Нийт төрөлт	1239	1235	-4
Үүнээс	Гэрийн төрөлт	4	5	1
	Охидын төрөлт	90	73	-17
	Охидын төрөлтийн эзлэх хувь	7.2	5.9	-1.3
6	Хэвтэн эмчлүүлэгчид	11477	11062	-415
7	Нас баралт	236	231	-5
8	0-1 насны эндэгдэл	18	14	-4
9	1-5 насны эндэгдэл	2	1	-1
10	Хурц халдварт өвчин	136	4343	4207

Үзүүлэлт	хэмжих нэгж	2020.9 сар	2021.9 сар	өөрчлөлт
Нялхасын эндэгдэл	1000 амьд төрөлтөд	14.4	11.3	-3.1
Үр хөндөлт	1000 амьд төрөлтөд	421.9	348.7	-73.2
Үүнээс охидын	хувь	7.8	10.9	3.1
Хурц халдварт өвчин	10000 хүн амд	19.4	60.7	41.3
БЗДХ	10000 хүн амд	38.3	11.4	-26.9
Үүнээс өсвөр үе	хувь	10.8	15.8	5
Хүүхдийн хяналт /0-1 нас/	хувь	70	76	6
Хүүхдийн хяналт /1-5 нас/	хувь	35	41	6

I. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 249473 хүнд үзлэг шинжилгээ хийсний 60.1%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
- Ортой эмнэлгүүдэд нийт 110621 хүнийг 74887 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.7 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
- Түргэн тусламжийн 7114 дуудлагад явж үйлчилсний 1093/15.3%/ нь алсын дуудлага, 498/7%/нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 83.3% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна.
- Нийт эмийн сангууд 53725 жор хүлээн авч 9 тэрбум 120 сая төгрөгний эм бараа борлуулалт хийсэн байна.
- ЭЭСангуудад нийт 10875 жор ирсний 53,3% /5807/ нь ЭМДаатгалын, 3,3%/364/ мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 43,2% /4704/ нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 81.2% байна.

II. БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛ, ЭНДЭГДЭЛ

- 9 сарын байдлаар 42849 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18228 тохиолдлоор буурсан байна. Нийт өвчлөлийн 63.7% нь шинэ өвчлөл байна.
- Үүнээс тэргүүлэх 5 өвчлөл нь:**

1. **Хоол шингээх эрхтний өвчин-11211** /47,6% шүдний цоорол, 28,6% ходоодны, 7% элэгний үрэвсэл/
2. Амьсгалын тогтолцооны өвчин-6514
3. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-5361 /Артерийн даралт ихдэх 54.8%, зүрхний ишемит өвчин 18,6%
4. Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин-4514
5. Мэдрэлийн тогтолцооны өвчин-3829

- 9 сарын байдлаар 1013 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 33 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 1-р, өвчлөл 91 тохиолдлоор буурсан байна.
- Осол гэмтлээр нас барагсдын 18.1%/6/нь амиа хорлосон-/Гт-1, Мн-1, Но-1, Сэ-1, Цц-1, Эх-1/, 42,4% /14/нь зам тээврийн осол-/Бд-1, Гт-1, Но-2, Нн-1, Хх-1, Цо-1, Цц-3, Боэт-3, Өо-1/, 39,3%/13/ нь бусад ослоор /Бо-2, Мн-2, Но-1, Хү-1, Цц-4, Шб-1, БОЭТ-2/ тус тус эндсэн байна.
- Осол гэмтлээр нас барагсад нь 87,8% /29/ эрэгтэй ба 7 нь эмнэлэгт хүргэгдсэн боловч 4 нь хоног болоогүй нас барсан байна. Бусад тохиолдлууд эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүй газар дээрээ нас барсан байна.
- Оны гарсаар 231 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 14,2% нь осол гэмтлээр, 22,5% нь хорт хавдраар, 9%/21/ нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 3% нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна. Нийт нас баралтын 45/19,4%/ нь эмнэлэгт, бусад нь гэртээ, хээр гадаа нас барсан байна.
- Нялхсын эндэгдлийн 14 /Бо-1, Гт-1, Мо-1, Но-1, Хб-1, Цц-1, БОЭТ-8/ тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 11,3% байна.
- Нялхсын эндэгдэл 2020 онд 50% нь эрт нярайн эндэгдэл байсан бол 2021 онд 50% нь эрт нярайн, 28,5% нь сараас дээш насны хүүхэд 4 байгаа ба 2 нь хатгаагаар, 2 нь осол гэмтлээр эндсэн байна
- БОЭТөвд 25 эндэгдэл тохиолдож задлан шинжилгээ 63,1% тай байна. Үндсэн оношийн зөрөө байхгүй.
- Нас баралтын шалтгаан:**

1. **Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-92**
2. Хорт хавдарын нас баралт-52
3. Бэртэл хордлого гадны шалтгаант нас баралт-33
4. Хоол шингээх эрхтний өвчин-21
5. Төрөх, перинаталь үед үүсэх эмгэг-7/ нярай/
6. Уушигны хатгаа- 6
7. Бөөрний эмгэг-7
8. Мэдрэлийн өвчин-4
9. Үжил-2
10. Уушигны бөглөрөлттэй-2
11. Ковид 19-3
12. Чихрийн шижингээр-2

III. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Нийт 1235 эх төрж 1236 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 4 төрөлтөөр хүн амын төрөлт буурсан байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна.
- Нийт төрөлтийн 5,9%/ 73/ охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна. /Бд-1, Бо-3, Бу-1, Гт-2, Мн-4, Но-1, Нн-1, Сэ-2, Хб-11, Хх-2, Хү-1, Цо-1, Цц-4, Шб-11, Өо-11, Эх-12, Бг-4/.
- 9 сарын байдлаар 431 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 348,7 байгаа нь өнгөрсөн оноос 73,2-р буурсан үзүүлэлт байна. Өсвөр насны охидын үр хөндөлт-47/10,9%/Бд-4, Бо-1, Бу-3, Гт-4, Мн-3, Но-1, Нн-1, Сэ-1, Хб-1, Хх-1, Цо-2, Цц-3, Шб-4, Өо-9, Эх-5, Бг-4/ байна.
- Үр хөндөлт 1000 амьд төрөлтөд 73,2-р буурч, охидын үр хөндөлт 3.1-р нэмэгдсэн байна.
- 9 сарын байдлаар сард дундажаар 5238 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 58.7% эзэлж байгаа нь хангалтгүй байна.

Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 7 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,1%-г эзэлж байгаа ба 14 хүүхэд туранхай, 10 хүүхэд өсөлтийн хоцрогдолтой байна.

- 0-1 насны хүүхдийн хяналт 6-р, 1-5 хүртэлх насны хүүхдийн хяналт 6-р тус тус нэмэгдсэн байна.

IV. ХАЛДВАРТ ӨВЧИН

- Он гараад 4553 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 4129 тохиолдлоор өссөн байна. Нийт халдварт өвчний 93,7% ковид-19, 0,08%-г салхинцэцэг, 0.1% сүрьеэ, 0.1%-г гар хөл амны өвчин, 0.2% цусан суулга, 1%-г хоолны хордлого, 1,8%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
- БЗДХ-н 24,3% нь жирэмсний үзлэгээс, 18,3% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 34,1% нь өвчний учир амбулатороор, 23,1% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна.

V. ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛГИЙН БАЙДАЛ.

Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн артерийн даралт ихсэх өвчин илрүүлэх үзлэгт 12308 чихрийн шижин илрүүлэх үзлэгт 12584, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 1136, хөхний хавдар илрүүлэх үзлэгт 6842, элэгний эрт илрүүлэгт 7635 хүн хамрагдаж үзлэг 37.5%-тай хийгдсэн байна. Энд сумдаас Булган, Гурвантэс, Номгон, Ханбогд, Цогтцэций сумд, Шимбилэг, Өнө-орших өрхийн эмнэлэгүүд харьцангуй бага хувьтай /50 доош хувьтай/ хамрагдсан байна. Эрт илрүүлэгт хамрагдсан иргэдээс артерийн даралт ихтэй 70 хүн шинээр оношлогдож хяналтад нэмж орсон байна.

ДЭЭРХ ҮЗҮҮЛЭЛТЭЭС ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. Охидын үр хөндөлт, БЗДХ өмнөх жилээс нэмэгдэх хандлагатай байгаад анхаарч өсвөр үеийн эрүүл мэнд, ялангуяа нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг сайжруулахад илүү үр дүнтэй ажил зохион байгуулах шаардлагатай.
2. Гэрийн 5 төрөлт нь алслагдсан хөдөө орон нутагт биш, аймгийн төв дээр тохиолдсон байгаа нь хөдөө орон нутгаас ирсэн эхчүүдийн хяналт, төрөх дөхсөн эхчүүдэд өгөх зөвлөгөө, мэдээллийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.
3. БЗДХ-н 53 % нь идэвхгүй үзлэг тандалтаар илэрсэн байгаа нь хүн амын дундах өвчлөлийн тархалт байгааг харуулж байгаа ба урьдчилан сэргийлэх үзлэг, илрүүлэлтийг идэвхжүүлэх шаардлагатай.
4. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болсон хоол боловсруулах эрхтэний болон зүрх судасны эмгэгийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, мэдээлэл сургалт сурталчилгаа, эрт илрүүлэг хяналт эмчилгээг сайжруулах
5. Осол гэмтлийн өвчлөл өнгөрсөн оноос нэмэгдсэн байгаа ба өвчлөлийн 25,4%, нас баралтын 42,4% зам тээврийн осол байна. Мөн осол гэмтлийн өвчлөлийн 62,9% нь гадны шалтгаан, орчин нөхцөл, ажлын байрны аюулгүй ажиллагаатай, 11,5% хүчирхийллийн шалтгаантай байгаад анхаарч осол гэмтлийн өвчлөл нас баралтыг бууруулахад салбан дундын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай.
6. Нас баралтын голлох шалтгаан нь цусны эргэлтийн тогтолцооны эмгэг буюу тархинд цус харвалт, зүрхний ишемит эмгэг зэрэг сэргийлж болох эндэгдэл тэргүүлж байгаа ба эрт илрүүлэлт, хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Эрт илрүүлгийн мэдээ 2021.9сар																	
Эмнэлгийн нэр		Артерийн даралт ихсэх өвчний эрт			Чихрийн шижингийн эрт илрүүлэг			Элэгний хавдарын эрт илрүүлэг/15-65/			Умайн хүзүүний эсийн шинжилгээ			Хөхний үзлэгт хамрагдсан хүн			Дундаж хувь
		хамрагдвал зохиx	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохиx	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохиx	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохиx	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохиx	хамрагдсан	хамрагдсан хувь	
1	Баяндалай	1027	623	60.7	1155	693	60.0	288	99	34.4	138	60	43.5	452	337	74.6	54.6
2	Баян-овоо	711	652	91.7	770	748	97.1	785	767	97.7	82	47	57.3	301	196	65.1	81.8
3	Булган	405	240	59.3	405	240	59.3	416		0.0	98		0.0	391	37	9.5	25.6
4	Гурвантэс	1383	262	18.9	1792	261	14.6	3408	192	5.6	252	140	55.6	1238	492	39.7	26.9
5	МандалОвоо	900	599	66.6	900	553	61.4	936	574	61.3	97	18	18.6	377	200	53.1	52.2
6	Манлай	1205	782	64.9	985	848	86.1	1538	25	1.6	152	75	49.3	592	311	52.5	50.9
7	Номгон	987	342	34.7	987	342	34.7	987	342	34.7	101	55	54.5	422	141	33.4	38.4
8	Ноён	395	374	94.7	395	374	94.7	987	994	100.7	103	53	51.5	375	240	64.0	81.1
9	Сэврээ	1140	832	73.0	1024	927	90.5	1090	24	2.2	127	81	63.8	460	447	97.2	65.3
10	Ханбогд	5312		0.0	5312		0.0	5312	242	4.6	355	53	14.9	1889	271	14.3	6.8
11	Ханхонгор	352	398	113.1	352	398	113.1	430	20	4.7	132	47	35.6	385	220	57.1	64.7
12	Хүрмэн	364	516	141.8	426	522	122.5	989	689	69.7	90	58	64.4	370	186	50.3	89.7
13	ЦогтОвоо	375	380	101.3	375	380	101.3	958	620	64.7	112	34	30.4	489	210	42.9	68.1
14	Цогтцэций	3500		0.0	3500		0.0	3500	445	12.7	400	34	8.5	2000	44	2.2	7.8
Сумын дүн		18056	6000	33.2	18378	6286	34.2	21624	5033	23.3	2239	755	33.7	9741	3332	34.2	31.7
15	Шимбилэг	4389	1081	24.6	4389	1081	24.6	2200	1035	47.0	623	198	31.8	2250	1071	47.6	35.1
16	ӨнөОрших	1344	523	38.9	1344	523	38.9	1115	501	44.9	462	112	24.2	1342	1022	76.2	44.6
17	Энхийнхүслэн	5132	4704	91.7	5246	4694	89.5	1903	1066	56.0	483	71	14.7	2218	1417	63.9	63.1
Өрхийн дүн		10865	6308	58.1	10979	6298	57.4	5218	2602	49.9	1568	381	24.3	5810	3510	60.4	50.0
Нийт дүн		28921	12308	42.6	29357	12584	42.9	26842	7635	28.4	3807	1136	29.8	15551	6842	44.0	37.5
9 сарын өссөн		22488	12308	54.7	22487	12584	56.0	20436	7635	37.4	3074	1136	37.0	12314	6842	55.6	48.1

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б. Мидэрсүрэн , Д. Гантогтох